



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 179 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татан буугдсан Мал хамгаалах сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 12,787,368.00 (арван хоёр сая долоон зуун наян долоон мянга гурван зуун жаран найман) төгрөгийн балансын үнэтэй, 11,173,939.46 (арван нэгэн сая нэг зуун далан гурван мянга есөн зуун гучин есөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Жамбалцэрэн, Татан буулгах комисс, тогтоолын хавсралтад заасан байгууллагын дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Татан буулгах комисс болон, байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) байгууллагад төвлөрүүлэх;

2.3.Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг байгууллагын хэрэгцээнд зориулалтын дагуу нөхөн сэргээж ашиглах;

2.4.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.5.Арга хэмжээний биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягтаар ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуул
2019 оны 28 дугаар сарын 22-ний ө
28 дугаар тогтоолын хавсралт

МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Балансын		Хуримтлагдсан элэгдэл	
				нэг бүрийн үнэ	нийт үнэ		
Ууламж							
Харуулын байр	ш	1	2014/06/30	125,474.00	125,474.00	20,912.28	
					125,474.00	20,912.28	
Тоног төхөөрөмж							
Асег иж бүрэн)	ш	2	2011/02/02	460,000.00	920,000.00	920,000.00	
Делл иж бүрэн)	ш	3	2011/03/11	759,000.00	2,277,000.00	2,277,000.00	
Делл)	ш	1	2009/06/30	1,042,800.00	1,042,800.00	1,042,800.00	
Делл)	ш	2	2015/04/01	949,000.00	1,898,000.00	1,898,000.00	
агч (Fago C6-312)	ш	2	2012/05/21	44,900.00	89,800.00	89,800.00	
Samsung SCX4828FCN)	ш	1	2011/02/01	349,000.00	349,000.00	349,000.00	
2014.10.30)	ш	1	2015.4.01	195,000.00	195,000.00	189,800.00	
агч (JK-1735GL)	ш	1	2012/05/21	29,900.00	29,900.00	29,900.00	
агч (JK-1730GL)	ш	1	2012/05/21	32,900.00	32,900.00	32,900.00	
					6,834,400.00	6,829,200.00	
Өгсэл							
мбар	ш	1	2015.6.30	385,000.00	385,000.00	308,000.16	
/	ш	1	2008/07/28	82,594.00	82,594.00	82,594.00	
ан	ш	1	2015.6.30	3,500,000.00	3,500,000.00	2,799,999.84	
(цайвар шар)	ш	1	2008/12/31	259,900.00	259,900.00	259,900.00	

н ханын шүүгээ	ш	1	2015.5.30	1,200,000.00	1,200,000.00	490,000.00	
					5,427,494.00	3,940,494.00	
ангамж							
программ	ш	1	2015.8.18	400,000.00	400,000.00	383,333.18	
					400,000.00	383,333.18	
НИЙТ ДҮН		21			12,787,368.00	11,173,939.46	
					(арван хоёр сая долоон зуун наян долоон мянга гурван зуун жаран найман)	(арван нэгэн сая нэг зуун далан гурван мянга есөн зуун гучин есөн төгрөг дөчин зургаан мөнгө)	(нэг сая арван дөрвөн найм)